



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/066/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил
Утас: 77665858

Цахим хаяг: Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139, Утас/Факс: (976) 7033 3141, Цахим шуудан: arkhangaiaudit@gov.mn	АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН 12 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН Ж.САРАНТУЯА ТАНАА
<p>2025.02.25 № 104.</p> <p>танай _____-ны № _____-г</p>	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 12 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 1,035,580.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 907,285.9 мянган төгрөгийг зарцуулан, орон нутгийн төсөвт 2,064.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, 126,230.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн 12 дугаар цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн</p>	

зорилтын 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 97.2 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

ДАНС	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	161,830,798.69	204,747,768.68
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	98,738,097.53	126,230,064.52
312	Банканд байгаа бэлэн мөнгө	98,738,097.53	126,230,064.52
3121	Төгрөг	98,738,097.53	126,230,064.52
31211	Төрийн сангийн харилцах	98,738,097.53	126,230,064.52
35	БАРАА МАТЕРИАЛ	63,092,701.16	78,517,704.16
351	Түүхий эд материал	1,494,400.00	1,494,400.00
35130	Эм боох материал	1,494,400.00	1,494,400.00
354	Хангамжийн материал	61,598,301.16	77,023,304.16
35410	Бичиг хэргийн материал	291,500.00	291,500.00
35420	Аж ахуйн материал	59,058,301.16	67,949,301.16
35450	Барилгын засварын материал	2,248,500.00	8,782,503.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,220,755,788.27	1,217,972,491.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,220,755,788.27	1,217,972,491.21
392	Биет хөрөнгө	1,168,919,288.31	1,167,187,491.21
39201	Барилга, байгууламж	1,220,668,091.00	1,220,668,091.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(101,722,341.00)	(122,066,809.20)
39205	Машин, тоног төхөөрөмж	59,003,215.63	82,852,715.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,501,896.32)	(31,801,317.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,343,453.88	30,001,453.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,522,184.88)	(20,895,592.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	5,160,000.00
39217	Номын фонд	650,950.00	3,268,950.00
393	Биет бус хөрөнгө	51,836,499.96	50,785,000.00
39301	Програм хангамж	2,417,500.00	2,417,500.00
39302	Хасагдуулга	(541,000.04)	(1,592,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	49,960,000.00	49,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,382,586,586.96	1,422,720,259.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4,563,497.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,563,497.00	-
413	Өглөг	4,563,497.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	426,650.00	-
4136	Бусад өглөг	4,136,847.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	4,136,847.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,378,023,089.96	1,422,720,259.89
51	Засгийн газрын хувь оролцоо	1,378,023,089.96	1,422,720,259.89
512	Хуримтлагдсан үр дүн	1,328,063,089.96	1,372,760,259.89
3	Өмнөх үеийн үр дүн	1,328,063,089.96	1,328,063,089.96
51220	Тайлант үеийн үр дүн	-	44,697,169.93
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	49,960,000.00	49,960,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,382,586,586.96	1,422,720,259.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	721,886,019.88	966,184,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,582,719.88	29,482,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,582,719.88	29,482,500.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	155,000.00	140,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,000.00	140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	28,427,719.88	29,342,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	693,303,300.00	936,702,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	595,790,300.00	821,250,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	595,790,300.00	821,250,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,513,000.00	115,451,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,513,000.00	115,451,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	660,012,209.07	921,487,630.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	660,012,209.07	921,487,630.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	643,736,525.31	919,423,254.46
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	385,306,504.20	614,645,584.01
210101	Цалин	284,755,670.64	432,279,183.12
210102	Нэмэгдэл цалин	82,242,646.86	154,436,412.69
210104	Урамшуулал	18,308,186.70	27,929,988.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,721,231.24	71,994,229.80
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,939,399.00	49,761,665.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,758,008.26	5,817,184.86
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,759,399.00	3,181,776.78
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	866,724.98	2,629,563.51
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,397,700.00	10,604,039.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,295,116.24	89,952,134.39
210301	Гэрэл цахилгааны зардал	4,602,779.24	5,742,127.00
210302	Түлш, халаалтын зардал	78,947,620.00	78,947,620.00
210303	Цэвэр, бохир усны зардал	3,744,717.00	5,262,387.39
2105	Нормативт зардал	54,467,898.00	76,739,152.20
210502	Хоол	54,467,898.00	76,739,152.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,784,350.00	9,959,240.00
210604	Урсгал засвар	3,784,350.00	9,959,240.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	942,500.00	1,898,200.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	942,500.00	1,898,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,218,925.63	54,234,714.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,247,004.00	14,039,657.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,655,200.00	4,126,260.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,316,721.63	36,068,797.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,275,683.76	2,064,375.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,257,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	9,257,800.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,064,375.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,064,375.61
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	7,017,883.76	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,017,883.76	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	61,873,810.81	44,697,169.93
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	6,889,520.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,889,520.00	-

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(6,889,520.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	54,984,290.81	44,697,169.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	693,458,300.00	936,842,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155,000.00	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	155,000.00	140,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	155,000.00	140,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,000.00	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	693,303,300.00	936,702,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	595,790,300.00	821,250,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	595,790,300.00	821,250,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,513,000.00	115,451,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,513,000.00	115,451,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	624,541,930.44	905,407,333.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	624,541,930.44	905,407,333.01
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608,266,246.68	903,342,957.40
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	385,293,237.44	614,645,584.01
210101	Үндсэн цалин	284,742,403.88	432,279,183.12
210102	Нэмэгдэл	82,242,646.86	154,436,412.69
210104	Үр дүнгийн урамшуулал	18,308,186.70	27,929,988.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,734,498.00	71,994,229.80
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,939,399.00	49,761,665.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,698,600.00	5,817,184.86
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,759,399.00	3,181,776.78
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	939,400.00	2,629,563.51
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,397,700.00	10,604,039.65
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	87,295,116.24	89,952,134.39
210301	Гэрэл цахилгааны зардал	4,602,779.24	5,742,127.00
210302	Түлш, халаалтын зардал	78,947,620.00	78,947,620.00
210303	Цэвэр, бохир усны зардал	3,744,717.00	5,262,387.39
2105	Нормативт зардал	54,041,248.00	77,165,802.20
210502	Хоол, хүнс	54,041,248.00	77,165,802.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.00	23,435,090.00
210604	Урсгал засвар	3,200,000.00	23,435,090.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	942,500.00	2,690,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	942,500.00	2,690,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,759,647.00	23,459,917.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,911,047.00	18,173,657.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,848,600.00	5,286,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,275,683.76	2,064,375.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,257,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	9,257,800.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,064,375.61

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,064,375.61
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,017,883.76	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,017,883.76	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	68,916,369.56	31,434,966.99
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	3,943,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,943,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,943,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,943,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(3,943,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	68,916,369.56	27,491,966.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,821,727.97	98,738,097.53
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,738,097.53	126,230,064.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	49,960,000.00	1,328,063,089.96	1,378,023,089.96
10	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	49,960,000.00	1,328,063,089.96	1,378,023,089.96
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49,960,000.00	1,328,063,089.96	1,378,023,089.96
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	44,697,169.93	44,697,169.93
18	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	49,960,000.00	1,372,760,259.89	1,422,720,259.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,035,580,200.00	907,285,957.40	128,294,242.60	87.61
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,035,580,200.00	907,285,957.40	128,294,242.60	87.61
210	Бараа, үйлчилгээний зардал	1,035,580,200.00	907,285,957.40	128,294,242.60	87.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,222,300.00	614,645,584.01	93,576,715.99	86.79
210101	Үндсэн цалин	511,948,600.00	432,279,183.12	79,669,416.88	84.44
210102	Нэмэгдэл	181,399,200.00	154,436,412.69	26,962,787.31	85.14
210104	Урамшуулал	14,874,500.00	27,929,988.20	(13,055,488.20)	187.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,143,700.00	71,994,229.80	10,149,470.20	87.64
210201	Тэтгэврийн даатгал	55,859,200.00	49,761,665.00	6,097,535.00	89.08
210202	Тэтгэмжийн даатгал	6,569,900.00	5,817,184.86	752,715.14	88.54
210203	ҮОМШӨ ний даатгал	3,285,700.00	3,181,776.78	103,923.22	96.84

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 12 дугаар цэцэрлэгийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	3,285,700.00	2,629,563.51	656,136.49	80.03
210205	Эрүүл мэндийн даатгал	13,143,200.00	10,604,039.65	2,539,160.35	80.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,015,600.00	89,952,134.39	2,063,465.61	97.76
210301	Гэрэл цахилгаан	4,790,900.00	5,742,127.00	(951,227.00)	119.85
210302	Түлш, халаалт	78,968,700.00	78,947,620.00	21,080.00	99.97
210303	Цэвэр, бохир ус	8,256,000.00	5,262,387.39	2,993,612.61	63.74
2105	Нормативт зардал	97,261,000.00	77,165,802.20	20,095,197.80	79.34
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	-	-
210502	Хоол, хүнс	97,261,000.00	77,165,802.20	20,095,197.80	79.34
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	-
2106	Эд хогшил худалдан авах	23,436,000.00	23,435,090.00	910.00	100.00
210604	Урсгал засвар	23,436,000.00	23,435,090.00	910.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,694,800.00	2,690,200.00	4,600.00	99.83
210806	Мэдээллийн технологийн зардал	2,694,800.00	2,690,200.00	4,600.00	99.83
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	29,806,800.00	27,402,917.00	2,403,883.00	91.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,901,200.00	19,498,657.00	2,402,543.00	89.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,905,600.00	7,904,260.00	1,340.00	99.98
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,035,580,200.00	934,777,924.39	100,802,275.61	90.27
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	821,250,700.00	821,250,700.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	821,250,700.00	821,250,700.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	115,451,600.00	113,387,224.39	2,064,375.61	98.21
132001	Орон нутгийн төсвөөс	115,451,600.00	113,387,224.39	2,064,375.61	98.21
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	98,877,900.00	140,000.00	98,737,900.00	0.14
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	140,000.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	98,737,900.00	-	98,737,900.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	98,738,097.53	(98,738,097.53)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	126,230,064.52	(126,230,064.52)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.00	28.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар явцад 3,274.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн бүртгэлийг залруулан ажилласан болно.

Аудитаар 207.0 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэн бөгөөд 207.0 мянган төгрөгт 1 төлбөрийн акт, 2 зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1. Төлбөрийн акт

Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийг үндсэн ажилтнаар ажиллуулж, нийт 207.0 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь : Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах

3.2.2. Нярвын программ ашиглалт, анхан шатны баримтын боловсруулалт, бараа материалын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр программд оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлд нярвын программыг ашиглалтыг сайжруулж бараа материалын гүйлгээг тухай бүртгэх, анхан шатны баримтыг программаар боловсруулж ажиллах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

Зөвлөмжийн биелэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, холбогдох нотлох баримтыг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Програмтай холбоотой	1	0					1	0				
Бараа материалтай холбоотой	1	0					1	0				
Дүн	2	0					2	0				